

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН 14 ДҮГЭЭР ХУРАЛ**

2020 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 13 цаг 37 минутад эхэлж, мөн өдрийн 17 цаг 10 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын танхимд хийж, нийт 03 цаг 33 минут хуралдав.

дд	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Ховд аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн төсөл хэлэлцүүлэх тухай.	Ховд аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн төслийг хэлэлцэх явцад гарсан саналыг тусган аймгийн Иргэдийн Төлөөлөгчдөд хэвлэж тарааж хэлэлцүүлэг зохион байгуулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхболдод үүрэг болгов.
2	Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааний хөтөлбөрийн төсөл хэлэлцүүлэх тухай.	Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааний хөтөлбөрийн төслийг дахин хянаж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдөд хэвлэж тарааж хэлэлцүүлэг зохион байгуулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхболдод үүрэг болгов.
3	Засаг даргын нөөц хөрөнгийн хүлээгдэж буй гүйцэтгэлийн тухай	Засаг даргын нөөц хөрөнгийн хүлээгдэж буй 14.217.753 төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ч.Багдалд, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхболд нарт тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР